

Research article

## “Элэг” хэмээх үгийг төрөл хэлнүүдийн хүрээнд харьцуулах нь

Үүрэгийн Ариунболд<sup>1</sup> , Гөлгөөгийн Болорцэцэг\*<sup>2</sup> 

<sup>1</sup>Монгол Улсын Боловсролын их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн  
Монгол хэлний тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор, Улаанбаатар, Монгол Улс

\*<sup>2</sup>Монгол Улсын Боловсролын их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн  
Монгол хэлний тэнхимийн гэрээт багш, доктор (Ph.D), Улаанбаатар, Монгол Улс

### ARTICLE INFO

#### History.

Received: 28 March, 2025

Revised: 09 June, 2025

Published: 05 June, 2026

#### Түлхүүр үг:

Алтай язгуур, авианы  
сэлгэлт, утга, шууд бус  
нэрлэлт

### ABSTRACT

Тус өгүүлэлд монгол, түрэг, манж-түнгүс хэлний зохих баримтуудыг харьцуулан “элэг” хэмээх үгийн утга, бүтэц, гарлыг тодорхойлов. Төрөл хэлнүүдийн баримтаас ажиглахад “элэг” хэмээх үгийн утга шилжсэнээр “ураг төрөл ~ зүрх сэтгэл ~ дотоод эрхтэн ~ хоол хүнс ~ хэвлий цээжний хэсэг” гэх мэтийн утгатай үгс үүсдэг байна. Алтай язгуурын хэлнүүдэд “элэг” гэсэн үгийн өмнө “нэг” гэх мэтийн утга бүхий тодотгох үгийг холбож, нэг эцэс эхээс төрсөн ахан дүүсийг нэрлэх нь нийтлэг тохиолддог. Алтай язгуурын төрөл хэлнүүдэд биений дотор эрхтэн “элэг”-ийг заасан нэр нь үгийн сангийн нийтлэг болон ялгаатай шинж энэ мэт хэдэн утгаар илэрхийлэгдэх бөгөөд энэ нь монгол, түрэг, манж угсаатнууд бие даасан хэлтэй болж салан хөгжихдөө өөр өөрийн хэлбэр бүтэцтэй болжээ. Тус өгүүлэл нь монгол хэлний уугуул үгийн сангийн бүрэлдэхүүн хэсэг болох хүний биений эрхтний нэр “элэг” хэмээх үгийг хол, ойрын төрөл хэлнүүдийн баримтад тулгуурлан, цуваа цагийн үүднээс утга, бүтцийн харьцуулал хийх замаар үүсэж бүтсэн зүй тогтол, түүхэн бүтцийг сэргээн тогтоож, гарлыг тайлбарлахыг зорьсон билээ. Бид монгол, түрэг, манж-түнгүс хэлнүүдийг харьцуулан авианы тогтолцоо, түүний хувьсан хөгжих зүй болон үгийн бүтэц, хэлзүйн хэлбэр хийгээд үгийн сангийн адил төсөөтэй онцлог шинжид тулгуурласан Г.И. Рамстедтын баримталж байсан алтайн хэлний онол болон профессор Ц.Өнөрбаян нарын “Хэлний шугаман бус хөгжлийн онол” -ыг үндэс болгож, төрөл хэл аялгуу, бичгийн дурсгалууд, түрэг, манж-түнгүс хэлний баримт, зэрэг хэрэглэгдэхүүнүүдийг шинжлэн дүгнэж боловсруулахдаа баримт хэрэглэгдэхүүнээр нотлон оюун дүгнэлт гаргах индукц, дедукцийн арга, бүртгэн жагсаасан зүйлүүдээ нэг бүрчлэн тайлбарлах замаар задлан шинжилгээ хийх анализ, тодорхойгоор дамжуулан ерөнхийг танин мэдэж, нэгтгэн дүгнэх синтезийн арга гэх мэт шинжлэх ухааны аргуудыг суурь болгон ашиглав.

© 2026, Author(s). This is an open access article under the CC BY-04 license (<https://creativecommons.org/licenses/by/4.0/deed.en>)

## 1. Оршил

Хүний биений таван цул эрхтний нэг болох “элэг” хэмээх үгийг “Монгол хэлний товч тайлбар толь”-д: “1.а. Хүн амьтны уушгины дор, өрцөд наалдаж тогтсон цөс боловсруулах нэгэн цулын нэр; б. (шилж) Садан төрөл., 2. Доог” (Цэвэл, 1966, хууд. 875) гэж гурван утга байгааг тайлбарласан байдаг бол “Хорин наймт тайлбар толь”-д үүнийг “Ургийн хамаатай хүнийг элгэн хэмээнэ. Бас ураг элгэн хэмээн холбон хэлэлцэнэ. Нэгэн төрлийн ах дүү нар ба ураг төрлийг элгэн хэмээнэ” (Горзоржав, Сампилноров, 1988, хууд. 211) хэмээжээ.

“Хүн төрөлхтөн ертөнцийн аливаа үзэгдлийн нууцыг танин мэдэхийн тулд хөгжлийнхөө явцад маш олон тооны таамаг, домог, онол, урсгал чиглэл гаргажээ. Эдгээрийг шугаман (вертикал) сэтгэлгээ, шугаман бус (латерал) сэтгэлгээнд хувааж үздэг” (Өнөрбаян, 2009, хуудсд. 35-45) хэмээн өгүүлсэн нь тун сонирхолтой юм. Хэлний аливаа нэгжийн өвөрмөц сонин чанарыг судлах олон талт түлхүүрийн нэг нь шугаман бус хөгжлийг илэрхийлэгч нутгийн аялгуу, аман болон салбар аман аялгуу, төрөл хэлнүүдэд байдаг билээ. Тэгвэл бидний ажигласнаар, “биеийн эрхтэн”, “ураг, хүйн

төрөл” гэх ерөнхий утгатай зэрэгцэн “зориг, зүрх”-гэй гэсэн давхар нэгэн утгыг монгол хэлнээ илэрхийлж байдаг. Энэ нь “helige-tür sölsütü, heregei-tür hončitan” гэсэн хэллэг нь монголчууд юмсыг танин мэдэх нь тухайн үзэгдлийн дүр байдал, шинж чанар зэргээр нь оюун ухаандаа тусган буулгасан ертөнцийн дүр зурагтай маш нарийн холбоотойг дээрх жишээнүүд илэрхийлсээр байна. Дунсян хэлнээ **gandzw** ~ **šwzo** гэж (Zhao na si tu, 1990, хууд. 257) “элэг”-г нэрлэж байгаа нь үүнтэй холбоотой байж мэднэ.

## 2. Үр дүн

Аливаа зүйлийн мөн чанар нь шүтэн барилдлагад тулгуурлан үүсэж, оршин тогтнодог билээ. Бусдаас ангид, бие даан ганцаар бус, хосолмол байдлаар орших бөгөөд эерэг сөрөг ойлголт ч мөн үүссэн. Энэхүү ойлголтыг монгол хэлний “элэг” хэмээх үгийн утгын хүрээнд авч үзвэл: “Монголын Нууц Товчоон” -ы 152-р зүйлд “hümegei helige ebüritcū yabuua” гэж “хорон муу санаа”-г, “Helāk kibe tūni” гэж “сүйтгэн үймүүлэх”-г (Поппе, 1938, хууд. 184) илэрхийлж байсан бол “элгэт төр”, “элэгсэг амраг” (Чоймаа, 2011, хууд. 166) зэрэг хоршоо үгээр “сайн төр”, “сайхан найзаа” нэрлэсээр байж. Түүнчлэн орчин үеийн монгол хэлний хэлц хэллэгт “сайн нохой мэрийн байж дайснаа дардаг, сайн хүн элэгсэг байж дайснаа ялдаг”, “морь ч эзэндээ ээлтэй газар бий, нохой ч өрхдөө элэгсэх сэтгэл бий” зэргээр “дотоо сэтгэл” -ийг илэрхийлж нохойн элэгтэн, өлөн элэг гэх мэтээр хорон муу санааг үйл хэргийн шинж, атаархан хорсох, хар санах, эв түнжин муудах зэрэг төлөөлсөн үүргээр хэрэглэж байна. Ертөнцийн юмс үзэгдэл бүхнийг хүн нүдээр харж, чихээр сонсоод, цээжинд сэтгэн бодож, үгээр дүрслэн илэрхийлдгийг дээрх жишээ баримт, хэлц хэллэгээс харж болох юм.

Хойшид монгол хэлэнд нэгэнт тогтоод байсан өөрийн үр удам, төрөл төрөгсдөө нэрлэсэн “ураг төрөл” гэх мэтийн дараагаар “доог тохуу” гэсэн утга үүсжээ. Үүнийг “аливаа хүн үзсэн сонссоноо хэлэлцэхэд инээдэм болох зүйл бий агаад тэсгэлгүй хөөрөлдөн инээхийг элэг хөштөл инээх” гэж хэлэлцдэг. Үүнээс элэглэгч ~ алиалагч гэсэн үг үүссэн байдаг бол ойрад аялгуунд элек, электе-“тохуурхах”, “хүчирхийлэх” (Баскаков, 1947, хууд. 190) зэргээр нэрлээд үүнээс электечи буюу “дооглогч, алиалагч” гэсэн шинэ нэрлэлтийг үүсгэдэг байна.

Төрөл хэлнүүдийн баримтаас ажиглахад “элэг” хэмээх үгийн утга шилжсэнээр “ураг төрөл ~ зүрх сэтгэл ~ дотоод эрхтэн ~ хоол хүнс ~ хэвлий цээжний хэсэг” гэх мэтийн утгатай үгс үүсдэг. Энэ нь монгол, түрэг хэлнүүдэд илүү тодорхой ажиглагдлаа.

Монгол хэлэнд **elige(n)** хэмээх энэ үг хүний эрхтнийг нэрлэхээс гадна дээрх нэрсийг бүтээхдээ ихэвчлэн “элэг” гэсэн үгийн өмнө ямар нэгэн үгтэй хоршиж, хэлц үүсгэн нэрлэдэг онцлогтой. Ингэж бүтсэн нэрийн хувьд утгын талаас цаашид өргөжиж, монгол хэлний үгийн санг арвижин баяжуулж байдгийн чухал нэгэн баримт юм.

Харин түрэг хэлнүүдэд багыр “**baγyr**” гэсэн үг нь “элэг”, “хоол хүнс”, “хэвлий цээжний хэсэг”, “цусан төрөл, хамаатан садан”, “дотор эрхтэн”, “дэлүү”, “уур хилэн”, “уй гашуу”, “хайр энэрэл”, “зүрх сэтгэл”, “доог тохуу” (Севортян, 1978, хууд. 19) гэх мэтийн утгуудтай бол манж-түнгүс хэлнүүдэд пāуа ~ пāка “элэг” (Озолина Л.В, Федяева И.Я, 2003, хууд. 254), хākан “элэг” (Болдырев, 2000, хууд. 280) “дэлүү”, “цөс болон цөсний хүүдий”, “өвчүү”, “цээж, цээжний яс” зэрэг утгыг илэрхийлдэг байна.

Алтай язгуурын хэлнүүдэд “элэг” гэсэн үгийн өмнө “нэг” гэх мэтийн утга бүхий тодотгох үгийг холбож, нэг эцэс эхээс төрсөн ахан дүүсийг нэрлэх нь нийтлэг тохиолддог. Тухайлбал, дундад үеийн монгол хэлэнд “хүй элэг, ураг элгэн”, “элэг мах” хэмээж байсан бол орчин цагийн монгол хэлнээ “нэг элгийн” гэх мэтээр ураг төрлийн хүнээ нэрлэж байгааг киргиз хэлний “бир боорум” буюу “миний ах, төрлийн хүн” (Юдахин, 1965, хууд. 145) гэсэн үг бүтсэн онцлогтой адилтган үзэж болох юм. Энэ байдал харин манж-түнгүс хэлнээ арай ялгаатай ажиглагдаж байна. Өмнө ямар нэгэн тодотгох үг авалгүйгээр ганц үгээр нэрлэдэг билээ. Жишээлбэл, эвенк хэлэнд цусан төрлийн хамаатан гэсэн үгийг “**нядю**” (Василевич, 1958, хууд. 309) гэж хэлж, өөрийн ах эгч болон нөхрийн

аав, ахыг эмэгтэйчүүд нь ингэж нэрлэдэг байна. Мөн орос хэлэнд ч “**пблусу**” (Озолина Л.В, Федяева И.Я, 2003, хууд. 270) гэж хамаатан садан, төрлийн хүнээ нэрлэж байгаа нь адил байдаг. Ер хүн төрөлхтний сэтгэхүйн бааз, оньс нь адил боловч юмс үзэгдэл, үйл байдлыг тусгаж, таньж мэдэх, хэлээрээ илэрхийлэх арга нь өөр өөр байдаг.

Түүнчлэн монгол хэлнээ тус үг нь аливаа зүйлийн өмнө этгээдийг заах бөгөөд түргийн киргиз, казак, узбек зэрэг хэлнүүдэд “**багыр**” гэсэн үгээр уулын энгэрийг заасантай утга үүргийн талаас дүйх юм. Ингэж нэрлэхээс гадна мөн туркмен, турк, узбек зэрэг хэлнүүдэд цээжийг нэрлэсэн нь өмнөд монгол хэлний ордос аялгуунд “элэг бөөрөө зод” гэж цээжиндээ цохих буюу цээжин хэсгээ хэлж байгаатай адил утгыг илэрхийлж байдаг.

Киргиз хэлэнд “элэг” гэсэн үндсэн утгатай “**боор**” нь өмнө дурдсан “ураг төрлийн хамаатан”, “уулын энгэр” гэх мэт утгыг илэрхийлдэг нь монгол хэл, аялгуунуудын онцлогтой тохирч байгаа хэдий ч “дэлүү”-г нэрлэсэн утгаараа эвенк хэлнээ “дэлүү”-г маш тодорхой ялган нэрлэхтэй адил байна. Тухайлбал, киргизэд “көк боор” хэмээн “дэлүү”-г нэрлэдэг бол эвенк хэлнээ “илэн” хэмээн “дэлүү”, “цөс болон цөсний хүүдий”, “элэг” (Романова А.В, Мыреева А.Н , 1968, хууд. 312) гэж ялган нэрлэдэг.

Үүнийг өмнөх бүлэгт дурдсан элэгний үйл ажиллагаатай болон “...сийвэнгийн бүрэлдэхүүн, тэдгээрийг үүсгэдэг ба задалдаг эрхтнийг (чөмөг, тунгалгийн зангилаа, элэг, дэлүү)” (Амарцэнгэл, 2023, хууд. 225) гэж нийтэд нь хамруулж тодорхойлсон байдаг зэрэгтэй үүрэг холбоогоор нь нэрлэсэнтэй холбон үзэж болох юм.

Энд утгын хувьд монгол хэлнээс яльгүй зөрж байгаа боловч үгийн хэлбэр, бүтэц тохирч байна.

Монгол хэлэнд “элэг” гэсэн үг нь мөн аливаа нэгэн үгтэй хоршин байж “ядарч зүдэрч тартагтаа тулах”, “бүтэлгүйтэх”, “бусдыг басамжлан дээрэлхэх”, “адил төсөөрөө нийлэх”, “харь хүн”, “бодол өөр санаа ондоо”, “сэтгэл зөөлөн, өрөвч, уярангуй”, “чин сэтгэлээсээ байх”, “зүрх сэтгэлдээ бодож хайрлах” гэх мэтийн олон утгыг илтгэх нь түрэг хэлний “**багыр**” гэсэн үгийн утгатай дүйцэж байдаг. Тодруулан үзвэл, монгол хэлнээ үр хүүхдээ хайрлан энхрийлэхдээ “элгэндээ тэврэх, элгэндээ наах” гэх зэргээр хэлдэг узбек хэлэнд “**bolasini bag'riga bosdi**” (Азизов О, Ризаева З , 1989, хууд. 14) гэж хүүхдээ хайрлан энхрийлж цээжиндээ тэврэхийг хэлдэг байна. Харин түрэг хэлнүүдэд “багыр” гэсэн үг нь заримдаа “өрц”, “сэдвийн эхний хэсэг” гэсэн утгыг илэрхийлдэг сонин зүйл ажиглагдана. Энэ дээр тайлбарласантай адилаар биеийн өмнө этгээдэд байдаг, юмны өвөр талыг заасан шинж чанарт үндэслэн үүссэн утга бололтой.

Ийнхүү алтай язгуурын төрөл хэлнүүдэд биеийн дотор эрхтэн “элэг” -ийг заасан нэр нь үгийн сангийн нийтлэг болон ялгаатай шинж энэ мэт хэдэн утгаар илэрхийлэгдэх бөгөөд энэ нь монгол, түрэг, манж угсаатнууд бие даасан хэлтэй болж салан хөгжихдөө өөр өөрийн хэлбэр бүтэцтэй болжээ.

Үүнийг тодруулан үзвэл, түрэг хэлнүүдэд монгол хэлтэй ойролцоо болон адил хэлбэртэй баримт ажиглагдахгүй байгаад үндэслэн \***fe** > **he** > **e**- түүхэн язгуураас гаралтай хүний эрхтний нэр болох “элэг” хэмээх үг нь уугуул монгол хэлэнд үүссэн гэж үзэж болно. Жишээлбэл: Түрэг бүлгийн хэлнүүдэд “багыр” хэмээн “элэг” -ийг нэрлэдэг боловч азербайжан, башкир, узбек, алтай зэрэг хэлнүүдэд утга нь шилжин “зүрх” -ийг илэрхийлдэг ажээ. Мөн турк, туркмен, азербайжан хэлнүүдэд ч шилжсэн утгаараа “цээж” -ийг нэрлэж байгаа бол лобнор, каракалпак зэрэгт гэдэс орчим буюу хэвлийн хөндийг, алтай аялгуунуудад “дотор эрхтэн” гэсэн утгатай байгаагаараа монгол хэлнийхээ ялгарч байдаг. Харин киргиз, казак гэх зэрэг хэлнүүдэд “цусан төрлийн хамаатан садан” -аа **багыр** буюу “элэг” гэсэн үгээр илэрхийлэх нь аливааг нэрлэн заах сэтгэлгээний хувьд адил боловч үгийн хэлбэр, бүтэц нь харин өөр байдаг байна.

Профессор В.Котвич энэ үгийн анхдагч хэлбэрийг \***fekin** гэж сэргээсэн нь башкир зэрэг хэлнүүдэд байгаа **пегыр, пеген** ~ **пегин** гэсэн хэлбэр болон манж-түнгүс хэлний \***fekin, пāya** ~ **пāka** “элэг”,

эвен. **xākān** “элэг”, “дэлүү”, “цөс болон цөсний хүүдий”, “өвчүү”, “цээж, цээжний яс” зэрэгтэй бүтцийн хувьд ойролцоо юм.

Мөн манж-түнгүс хэлнүүдийн хувьд **элигэн** гэсэн хэлбэр зөвхөн эвенк хэлнээ тохиолдож, өөр бусад хэлнээ үл тохиолдох нь энэ үг монгол хэлний “элэг” гэсэн хэлбэрээс гаралтай болох нь илэрхий юм. Түүнчлэн **илэн** гэсэн үгээр “дэлүү”, “цөсний хүүдий” -ийг нэрлэх нь дээрхтэй ижил юм.

Монгол хэлний энэхүү үгийн бүтэц төрөл хэлнүүдэд дараах байдлаар тохиолдож байна. Тухайлбал, **элэг, илэг, элиг, илг, елүэн, елеге, элиг, илэг, элэх, илэх, жилэг, гаа, elk, elek** зэрэг болно.

Тус “элэг” хэмээх үгийн талаар профессор М.Базаррагчаа: “Бидний санавал, “eleg” хэмээх үгийн “e” эгшиг нь “a” -тай сэлгэж “хоёроос дээш өнгө алаглан оролцсон өнгө” гэсэн утга бүхий “alag” (алаг) хэмээх үг салаалсан байна” (Базаррагчаа, 2020, хууд. 346) хэмээн тайлбарласан байдаг. Мөн тус үгийн гарлыг “э-гэ-ли (ээл, ээлтэй) хэмээх үгийн “-ли” үе нь урагш тонгорч, “э-ли-гэ” (элэг, элэгтэй, ээлтэй) хэмээх үг бүтсэн байж магадгүй” (Базаррагчаа, 1994, хууд. 445) гэж үзжээ.

Монгол бичгийн хэлэнд **eligen** гэж бичигддэг энэ үг эртний болон дундад үеийн монгол хэлний дурсгалуудад **\*keligen** гэсэн хэлбэртэй байжээ.

Үүнийг профессор Н.Поппе “**eligen**[<**\*heligen**] [<**\*feligen**]” (Poppe, 1987, хууд. 46) гэж сэргээсэн байдаг бол академич Д.Төмөртоогоо “**\*feligen** > **AM \*xeligen** > (**h**)**eligen** (**Bur.**) = **MM heligen** (**MNT, Hy, IM**), **helige** (**MNT, IM**) > **eligen** (**Mu**); **CM xaliege** (**Mngr.**), **xeleg** (**Dag, Kul**), **xelge** (**Bao**) // **helegen** (**SY**), **helehe** (**But.**) // **elegen** (**Khori**), **elege** (**Ord**), **elegэ** (**TMon, ÖMon.**) “элэг” (Төмөртоогоо, 2022, хууд. 68) гэж бас үгийн гарал, хэлбэр бүтцийг сэргээжээ.

Энэхүү үгийн эхний уруулын шүргэх **\*f** гийгүүлэгч нь хойшид уруулын шинжээ алдаж эртний монгол хэлний үед шүргэх **\*x**, дундад үеийн монгол хэлний үед сул шүргэх **\*h** болоод улмаар олонх хэл аялгуунуудад бүрмөсөн гээгдэж хэл, аялгуунуудад “Cha., Barin., Barg., Sön. **элэг**, **Bur. элэгин**, **Khar. жилэг**, **Ord. eleg**, **Alasha. elek**, **Oir. elkin**, **Dag. хэлэг**, **SY. heleye**, **Mngr. xelge**, **Dun. gandzu**, **Bao. helge**” хэлбэртэй болжээ.


- Язгуурын **e-** эгшиг бол монгол хэлэнд өмнө - [Mo. emüne], энхэлзүүр - [Mo. eŋkeljegür], энгэр - [eŋger], өвчүү - [Mo. ebčigüü], элэг - [Mo. elige] мэтийн үгсийг үүсгэсэн “өмнө” гэсэн утгатай түүхэн бүтээвэр болно.
- Харин **-li** дагавар бол тухайн зүйлийн бодит утгыг үүсгэж **eli huli** гэсэн нэгэн үгийг үүсгэдэг байна.

Тэгвэл “-гэн” гэсэн дагаврыг академич Л.Болд: “Уул дагавар нь монголын нууц товчоо”-нд -γan, ~-gen хэлбэртэй хүний эшийн холбогдолтой нэр үүсгэдэг байна. Энэ язгуур нь монгол бичгийн хэлнээ **obu** (< **obuy**), **öbü** (<**öbügen**) бөгөөд Орхон бичгийн дурсгалд гардаг **oba** “аймаг” (20:362) үгтэй харьцуулбал, **obu-γ**, **öbü-gen** гэсэн бүтээврүүд болон задарна” (Болд, 1986, хууд. 89) хэмээжээ.

Элэг нь ойр дотнын, ураг төрлийн гэх санааг илэрхийлдэг бөгөөд “садан” гэх үгтэй хоршин ойр дотнын хэмээх санааг илэрхийлдэг ажээ. Ингэж үзвэл тус дагавар нь хүний хамаатай үг үүсгэнэ.

Монгол хэлний **e-** язгуураас үүссэн зарим үгсийн бүтцийг ажиглавал доорх мэт байна.

Зураг 1. **\*e-** язгуураас үүссэн зарим үгсийн бүтэц



Нэгэн зүйлийг нэмэн дурдахад, монгол хэлний олон хэл, аялгуунуудын дундаас дунсян хэлнээ **gandzu** гэж тохиолдож байгаа нь магадгүй солонгос хэлний gan “элэг” гэх үгтэй тохирч байж болох юм.

### Дүгнэлт

1. Монгол төрөл хэлнээ “элэг” хэмээх үг нь “биеийн эрхтэн”, “ураг, хүйн төрөл”, “дотно сэтгэл, “доог тохуу”, “өмнө тал” гэх ерөнхий утгатай зэрэгцэн “зориг, зүрх”-тэй гэсэн давхар нэгэн утга илэч байдаг бол түрэг хэлнүүдэд багыр “**baγyr**” гэсэн үг нь “элэг”, “хоол хүнс”, “хэвлий цээжний хэсэг”, “цусан төрөл, хамаатан садан”, “дотор эрхтэн”, “дэлүү”, “уур хилэн”, “уй гашуу”, “хайр энэрэл”, “зүрх сэтгэл”, “доог тохуу”, манж-түнгүс хэлнүүдэд *pāya ~ pāka* “элэг” *hākān* “элэг” “дэлүү”, “цөс болон цөсний хүүдий”, “өвчүү”, “цээж, цээжний яс” зэрэг утгыг илэрхийлдэг байдаг онцлогтой байна.
2. Ийнхүү алтай язгуурын төрөл хэлнүүдэд биеийн дотор эрхтэн “элэг” -ийг заасан нэр нь үгийн сангийн нийтлэг болон ялгаатай шинж энэ мэт хэдэн утгаар илэрхийлэгдэх бөгөөд энэ нь монгол, түрэг, манж угсаатнууд бие даасан хэлтэй болж салан хөгжихдөө өөр өөрийн хэлбэр бүтэцтэй болжээ.
3. **\*fe > he > e-** түүхэн язгуураас гаралтай хүний эрхтний нэр болох “элэг” хэмээх үг нь уугуул монгол хэлэнд үүссэн. Түрэг бүлгийн киргиз, казак гэх зэрэг хэлнүүдэд “цусан төрлийн хамаатан садан” -аа **багыр** буюу “элэг” гэсэн үгээр илэрхийлэх нь аливааг нэрлэн заах сэтгэлгээний хувьд адил боловч үгийн хэлбэр, бүтэц нь харин өөр байдаг байна.
4. Энэхүү үгийн эхний уруулын шүргэх **\*f** гийгүүлэгч нь хойшид уруулын шинжээ алдаж эртний монгол хэлний үед шүргэх **\*x**, дундад үеийн монгол хэлний үед сул шүргэх **\*h** болоод улмаар олонх хэл аялгуунуудад бүрмөсөн гээгджээ.
5. Язгуурын **e-** эгшиг бол монгол хэлэнд өмнө - [Mo. emüne], энхэлзүүр - [Mo. eŋkeljegür], энгэр - [eŋger], өвчүү - [Mo. ebčigüü], элэг - [Mo. elige] мэтийн үгсийг үүсгэсэн “өмнө” гэсэн утгатай түүхэн бүтээвэр болно. Харин **-li** дагавар бол тухайн зүйлийн бодит утгыг үүсгэж **eli huli** гэсэн нэгэн үгийг үүсгэдэг байна. Тэгвэл -*γan*, ~ -*gen* хэлбэртэй хүний дагавар нь хүний хамаатай үг үүсгэж байна.

### Analysis and of Word “eleg” Related Languages

Ariunbold Uureg<sup>1</sup> , Bolortsetseg Gulguu<sup>\*2</sup> 

<sup>1</sup>Ph.D., Associate professor, the Department of Mongolian Language, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

<sup>\*2</sup>Ph.D., Adjunct Lecturer, Department of Mongolian Language, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

**Abstract:** This article presents a comparative analysis of the meaning, structure, and etymology of the word *eleg* (“liver”) by examining relevant data from the Mongolic, Turkic, and Manchu-Tungusic language families. Based on evidence from these genetically related languages, it is observed that the semantic field of the word *eleg* extends metaphorically to encompass meanings such as “blood kin~heart and mind~internal organ~food~abdominal and thoracic region.” In the Altaic languages, it is common to modify the word *eleg* with adjectives denoting unity (e.g., “one”) to refer to siblings born of the same parents. In Mongolic, the word *eleg* also appears in various idiomatic expressions conveying meanings such as “to reach the limit of exhaustion,” “to fail,” “to despise and dominate others,” “to be united by similarity,” “a foreigner,” “a person with a different mindset,” “soft-hearted and compassionate,” “to be sincere,” and “to hold dear in one’s heart.” These semantic extensions are comparable to those of the Turkic word *bagır* (“liver”). The word *eleg*, denoting a human organ, likely originated in Proto-Mongolic, tracing back to the historical root “*eligen*.” In languages such as Kyrgyz and Kazakh, blood relatives are referred to by the word *bagır* (“liver”), which reflects a shared conceptual metaphor but differing phonological and morphological structures. Furthermore, in the Manchu-Tungusic languages, the form *eligen* occurs solely in Evenki, and is absent in other related languages, suggesting that this form was derived from the Mongolic *eleg*. In the Altaic language family, the lexical item denoting the internal organ “liver” is expressed through several common and divergent meanings across the member languages. These lexical and semantic variations have emerged as the Mongolic, Turkic, and Tungusic peoples developed independent languages, each evolving its own distinct structural features. This article aims to reconstruct the historical structure and explain the etymology of the native Mongolic term “*eleg*” (“liver”)—a lexical item referring to a human internal organ—by conducting a diachronic semantic and morphological comparison based on data from both closely and distantly related languages. The analysis draws on the phonological systems, their historical evolution, morphological structures, grammatical forms, and lexical similarities across Mongolic, Turkic, and Tungusic languages. The study is grounded in G.J. Ramstedt’s Altaic hypothesis, which is based on comparative linguistic features, as well as in Professor Ts. Önörbayan’s “Non-linear Theory of Language Development.” Primary sources include dialectal data, written monuments, and lexical evidence from Turkic and Tungusic languages. The methodological framework incorporates scientific approaches such as induction and deduction—drawing general conclusions from specific evidence and vice versa—as well as analytic methods involving the detailed examination and explanation of each recorded item. Additionally, synthetic reasoning is employed to generalize from specific findings and to form comprehensive conclusions. These methods collectively support the linguistic reconstruction and comparative analysis undertaken in this study.

**Keywords:** *Altaic languages, phonetic change, semantics, metaphorical designation.*

## Reference

- Amartsengel, O. (2023). *Hüinii fiziologi*. [Human Physiology]. Ulaanbaatar: Soyombo Press
- Bazarragchaa, M. (1994). *Mongol ügiin garliig möshgöh ni* [Etymology of mongolian words]. Ulaanbaatar
- Bazarragchaa, M. (2020). *Mongol ügiin garliig möshgöh ni* [Etymology of mongolian words]. Ulaanbaatar
- Bold, L. (1986). *Orchin tsagiin mongol helnii züi*. [A grammar of contemporary mongolian]. Ulaanbaatar
- Gorzorjav, Sampilnorov. (1988). *Horin naimtiin tailbar toli*. [Explanatory Dictionary of Khorin Naimt]. Höhhot: Övörmongoliin ardiin hevleliin horoo.
- Önörbayan, Ts. (2009). *Mongol helnii shugaman bus högjliin onoliin asuudald*. [On the Theory of Non-Linear Development in Mongolian]. *Mongol sudlaliin chuulgan* №7.

- Tömörtogoo, D. (2022). *Mongol hel sudlal V boti, tүүhen hel зүү*. [Mongolian linguistics, volume V, historical grammar]. Ulaanbaatar
- Tsevel, Y. (1966). *Mongol helnii товч тайлбар толи*. [A Concise explanatory dictionary of the mongolian language]. Ulaanbaatar
- Choimaa, Sh. (2011). *Ertнii haadiin үндесlesen төр yosнii zohioliig товчлон хураасан алтан товч hemeeh орshvoi*. [The Altan Tobchi is a compendium of the statecraft writings of the ancient khans]. Ulaanbaatar: Мөнhiin үсег.
- Azizov O, Rizaeva Z. (1989). *Uzbek–Russian Dictionary*. Tashkent: Ukituvchi.
- Baskakov, N. (1947). *Oirot–Russian dictionary*. Moscow.
- Boldyrev, B. (2000). *Evenki–Russian dictionary*. Novosibirsk.
- Vasilevich, G. (1958). *Evenki–Russian dictionary*. Moscow.
- Ozolinya, L. V., & Fedyaeva, I. Ya. (2003). *Orok–Russian and Russian–Orok dictionary*. Yuzhno-Sakhalinsk.
- Romanova, A.V., & Myreeva, A. N. (1968). *Dialectological dictionary of the Evenki language*. Leningrad: Nauka.
- Poppe, N. (1938). *Mongolian dictionary Mukaddimat al-Adab I–II*.
- Sevortyan, E.V. (1978). *Etymological dictionary of the Turkic languages*. Moscow: Nauka.
- Yudakhin, K.K. (1965). *Kyrgyz–Russian dictionary*. Moscow.
- Poppe, N. (1987). *Introduction to Mongolian comparative studies*. Helsinki.
- Zhao na si tu. (1990). *Menggu yuzu yan cidian*. Qinghai.